



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 1670

Ховд

Хуучин 1,2,3,4 дүгээр 30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын нэмэлт ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Рашаант дарцагт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хуучин 1,2,3,4 дүгээр 30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын нэмэлт ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Цэдэнбал - Монгол Улсын Гавьяат барилгачин  
Д.Цогтхүү - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байцаагч  
Б.Бямбахүү - Жаргалан багийн нийгмийн ажилтан  
Д.Бурмаа - “Оргил” сууц өмчлөгчдийн холбооны байцаагч  
Д.Галя - 4-30 айлын оршин суугчдын төлөөлөл  
Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн  
С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга  
Б.Гантоого - “Рашаант дарцагт” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2.

2. “Рашаант дарцагт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН